



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 187

Мандалговь

Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын
2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, 66.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 12.1, 12.2, 12.5, дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг хавсралтаар баталсугай.

2. Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “Санаачилгатай сайн” үнэлэгдэж тэргүүн байр эзэлсэн Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрыг Засаг даргын өргөмжлөл 2,000,000 (Хоёр сая) төгрөгөөр, дэд байр эзэлсэн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрыг Засаг даргын өргөмжлөл 1,500,000 (Нэг сая таван зуун мянга) төгрөгөөр, гутгаар байр эзэлсэн Луус сумын Засаг даргын Тамгын газрыг Засаг даргын өргөмжлөл 1,000,000 (Нэг сая) төгрөгөөр тус тус шагнасугай.

3. Тэргүүн байр эзэлсэн Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын даргыг нэг сарын үндсэн цалин, дэд байр эзэлсэн Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын даргыг сарын үндсэн цалингийн 90 хувь, гутгаар байр эзэлсэн Луус

2024100189

сумын Засаг даргын тамгын газрын даргыг сарын үндсэн цалингийн 80 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг байгууллагын төсөвтөө багтаан шийдвэрлэхийг сумдын Засаг дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүрэг болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шинэ санал санаачилга гарган сум, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

5. Сумдын Засаг даргын Тамгын газрыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Н.Түвшинжаргал)-т даалгасугай.

6. Үйл ажиллагааны үр дүнгээр 1, 2, 3 дугаар байр эзэлсэн сумдын шагнал болон бусад зардалд шаардагдах 5,129,200 (Таван сая нэг зуун хорин есөн мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 сарын 21-ны
өдрийн № дугаар захирамжийн хавсралт

СУМДЫН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

№	Сумдын нэрс	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ		Дундаж	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ				Дундаж	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ			Дундаж	Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, онцлох ажлын үнэлгээ	Дундаж	Ерөнхий үнэлгээ
		Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт		Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгжилт		Мэдээллийн ил тод нээлттэй байдал	Шилэн данс хөтлөлт, ОНХС-ийн хэрэгжилт	Хөндлөнгийн үнэлгээ				
1	САЙНЦАГААН	95.3	80.5	87.9	87.3	89.9	98	79.9	88.8	70.8	89.9	84.2	81.6	79.2	79.2	84.4
2	БАЯНЖАРГАЛАН	88.6	73.9	81.3	80.1	88.5	96	87.9	88.1	47.5	71.8	75.9	65.1	75.2	75.2	77.4
3	АДААЦАГ	89	65.8	77.4	82.5	87.5	98	82.6	87.7	76.7	85.7	82.6	81.7	77.7	77.7	81.1
4	ӨЛЗИЙТ	90	77.6	83.8	80.1	90.8	98	82.7	87.9	45.8	84.9	70.9	67.2	84.4	84.4	80.8
5	ДЭРЭН	89.3	73.2	81.3	85.3	87.0	96	88.8	89.3	37	99.5	78.7	71.7	78.6	78.6	80.2
6	ӨНДӨРШИЛ	88.4	64.6	76.5	80.5	95.2	92	89.7	89.3	78.3	89.9	79.1	82.4	77.7	77.7	81.5
7	ЭРДЭНЭДАЛАЙ	96	77.8	86.9	89.1	94.0	96	92.5	92.9	85.3	92.2	86.3	87.9	93.5	93.5	90.3
8	ДЭЛГЭРЦОГТ	96.2	80.3	88.3	90.0	97.5	96	96.8	95.1	60.8	99.9	88.5	83.1	95.8	95.8	90.5
9	ЛУУС	94.9	74.9	84.9	84.6	98.5	96	93.8	93.2	87.8	98.2	86.4	90.8	91.9	91.9	90.2
10	ГОВЬ-УГТААЛ	85.7	71.8	78.8	76.5	89.2	88	85.3	84.7	50	85.3	84.2	73.2	84.5	84.5	80.3
11	САЙХАН-ОВОО	91	68.6	79.8	82.2	93.5	96	89.4	90.3	49.2	83.2	80.5	71.0	81.7	81.7	80.7
12	ЦАГААНДЭЛГЭР	84	79.5	81.8	70.5	89.5	96	79.0	83.7	87.5	83.7	73.4	81.5	68.9	68.9	79.0
13	ГУРВАНСАЙХАН	88.7	71.1	79.9	84.9	90.9	95	87.5	89.6	40.8	74.5	76.6	64.0	86.4	86.4	80.0
14	ДЭЛГЭРХАНГАЙ	89.7	77.6	83.7	76.4	89.7	96	88.5	87.7	45.2	84.6	77.0	68.9	81	81.0	80.3
15	ХУЛД	90	75.7	82.9	77.3	83.6	92	75.9	82.2	75.3	90.6	74.9	80.3	78	78.0	80.8
	ДҮН	90.5	74.2	82.3	81.8	91.0	95.3	86.7	88.7	62.5	87.6	79.9	76.7	81.0	82.3	82.5
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС																